

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

ПҮРЭВСҮРЭНГИЙН САНДАГСҮРЭН

**ХЭВИЙН ЗУУЛТТАЙ 18-22 НАСТАЙ ХҮНИЙ ЭГЦ УРДААС АВСАН
ТЕЛЕРЕНТГЕН ЗУРГИЙН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ**

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч

АУ-ны доктор дэд профессор Б.Амарсайхан

Анагаах ухааны магистрийн зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл

Улаанбаатар

2011 он

ТОВЧ ХУРААНГУЙ

Хэвийн зуулттай 18-22 настай хүний эгц урдаас авсан телерентген зургийн дундаж үзүүлэлт

Үндэслэл

Телерентген зургийн шинжилгээг нүүр амны гажгийг оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулахаас гадна эмчилгээний явц, үр дүнг тооцох, хүүхдийн эрүү нүүрний өсөлтийг хянахад хэрэглэдэг. Нүүр амны гажиг заслын практикт рентген оношлогоо нь ихэвчлэн хажуугийн телерентген зураг дээр үндэслэсэн байдаг. Эгц урдаас авсан телерентген зураг нь хоншоор эрүүний өргөний харьцаа, тэгш хэмт байдал, нүүр амны хөндлөн чиглэлд үүссэн гажгийн талаар нарийн мэдээлэл өгдөг чухал ач холбогдолтой нэмэлт шинжилгээний арга юм. Судлаачид судалгааны үр дүндээ үндэслэн нэг үндэстэн, угсаатны телерентген зургийн дундаж үзүүлэлтийг өөр үндэстэн угсаатны нүүр амны гажиг заслын болон нөхөн сэргээх мэс заслын эмчилгээнд лавламж хэмжээ болгон ашиглах нь тохиромжгүйг тэмдэглэжээ. Дээрхи байдлыг харгалзан үзэж тодорхой нэг үндэстэн угсаатан дунд тохиолдох нүүр амны гажиг заслын эмчилгээ, эрүү нүрний нөхөн сэргээх мэс заслын эмчилгээг тэдгээрийн онцлог шинж байдалд тохируулан хийх шаардлагатай нь судалгааны ажлын үндэслэл болж байна.

Зорилго

Хэвийн зуулттай 18-22 настай эрэгтэй, эмэгтэй хүний эгц урдаас авсан телерентген зургийн дундаж үзүүлэлтийг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго оршино.

Хэрэглэгдэхүүн, арга зүй

Судалгаанд хэрэглэгдэх эгц урдаас авсан телерентген зургуудыг ЭМШУИС-ийн Нүүр Ам Судлалын Сургуулийн архиваас түүвэрлэсэн. Телерентген зургийг түүвэрлэхдээ эрүү нүүрний дэлгэмэл рентген зураг болон хажуугийн телерентген зургийг үндэслэн доорх шалгуур үзүүлэлтээр сонгон авав. Телерентген зургийг түүвэрлэсэн шалгуур үзүүлэлт:

- Бүрэн шүдтэй (агт араа ургаагүй байж болно)
- Шүд цооролгүй байх эсвэл цөөн тооны бүрэн эмчлэгдсэн шүдтэй байх
- Хэвийн зуулттай

Сонгогдсон телерентген зургуудад Winceph 8.0 программыг ашиглан 24 цэгийг байрлуулж, 16 үзүүлэлтийг нэг судлаач хийж гүйцэтгэсэн. Судалгааны статистик боловсруулалтыг SPSS-17 программ ашиглан хамгийн их, хамгийн бага утга, дундаж утга, стандарт хазайлт зэргийг тодорхойлсон. Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж үзүүлэлтүүдийг харьцуулахад *2 Independent t test* ашигласан.

Үр дүн

Хамрын өргөн, JL-FFP ба JR-FFP үзүүлэлт хүйсийн хувьд статистик үнэн магадлалтай ялгаа илрээгүй бол хацрын өргөн, хоншоорын өргөн, эрүүний өргөн, эрүүний соёо хоорондын өргөн, эрүүний 1-р их араа хоорондын өргөн зэрэг үзүүлэлтэд хүйсийн хувьд статистик үнэн магадлалтай ялгаа илэрсэн.

Дүгнэлт

Судалгааны үр дүнд гарсан эгц урдаас авсан телерентген зургийн дундаж үзүүлэлтийг нүүр амны гажиг засалын болон нөхөн сэргээх мэс заслын эмчилгээний үед лавламж хэмжээ болгон ашиглах боломжтой юм.

Түлхүүр үг: Эгц урдаас авсан телерентген зураг, хэвийн үзүүлэлт

ABSTRACT

Posteroanterior cephalometric norms for normal people between 18 and 22 years of age

Introduction

Cephalometric radiography is an essential tool in clinical orthodontics. The use of cephalometric radiographs to investigate growth and development of the facial skeleton can assist in treatment planning, and changes between pre and post-treatment measurements can help in treatment evaluation. Many facial and radiographic records in orthodontics are based on the profile. The posteroanterior cephalogram contains diagnostic information about evaluate the width and transverse position of the maxilla and mandible, transverse problem such as crossbite and bilateral facial asymmetries. Cephalometric norms for different ethnic and racial groups have been established in many studies. Most investigators have concluded that there are significant differences between various ethnic and racial groups, and, as a result, a number of cephalometric standards have been developed. All these studies indicated that normal measurements for 1 group should not be considered normal for every race or ethnic group. Different racial groups must be treated according to their own characteristics.

Object

The main purpose of this study was to establish posteroanterior cephalometric norms for normal people between 18 and 22 years of age.

Material and method

Posteroanterior cephalograms were chosen from radiographic archive of School of Dentistry, Health Sciences University of Mongolia. They met following criteria based on panoramic radiography and lateral cephalogram: all permanent teeth present (third molar may not be present), no caries and well-aligned maxillary and mandibular dental arches. Cephalograms were traced and measured by Winceph 8.0 programm, and whole measurements made by 1 investigator. Twenty-four landmarks were identified, sixteen transverse linear measurements were measured on each radiograph. All statistical analyses were performed with a commercial software package SPSS 17. For each variable, mean, standard deviation, and minimum and maximum values were

calculated. To compare the changes observed in men and women, independent-samples t tests were performed.

Result

No statistically significant sex differences were found in the nasal width, the JL-FFP and JR-FFP distances. Statistically significant sex differences were found in the, maxillary width, mandibular width, mandibular intercanine width, mandibular intermolar width, and Facial width.

Conclusions

These Mongolian posteroanterior cephalometric norms can be used in the treatment of Mongolian patients.

Key word: Posteroanterior cephalometry, norms